Оюутнуудын биеийн өвөрмөц чанарыг судалсан дүн

Зангин[1], Зунаа[2], Ван Юе Хун[3], Ц.Одгэрэл[4]

[1]ӨМАУИС-ийн 2018 оны аспирант (010110)
[2]ӨМАУИС-ийн оюутан (010110),
[3]ӨМАУИС, дотор өвчин судлалын тэнхим
[4]АШУУИС, Цус судлалын тэнхим

Түлхүүр үг:
Биеийн өвөрмөц чанар
Монгол анагаах ухаан
Биеийн жингийн индекс

Товч утга: Үндэслэл: Монгол анагаах ухааны онолоор “Биеийн өвөрмөц чанар” нь эцэг эхийн дусал нийлэн үр хөврөл тогтож, бойжих явцад бүрэлдэх ба амьдралын туршид тухайн бодгалийн онцлогыг тодотгох төрөлх чанар болдог. **Зорилго:** Монгол анагаах ухааны биеийн өвөрмөц чанарын тархалтыг оюутны биеийн жингээс хамааруулан судлахаар зорив. **Судалгааны хэрэглэгдэхүүн ба арга зүй:** Судалгаанд Өвөр Монголын Анагаах Ухааны Их Сургуулийн оюутнуудыг санамсаргүй түүврийн аргаар сонгон, “Монгол Анагаах Ухааны Үндсэн Онол” дах биеийн өвөрмөц чанарын ерөнхий илрэлийг үндэслэн, биеийн өвөрмөц чанарыг ялган тогтоов. **Үр дүн:** Судалгаанд 381(эрэгтэй 122 (32.02%), эмэгтэй 259 (67.98%)) оюутныгсонгож авсан. Монгол анагаах ухааны аргачлалын дагуу биеийн өвөрмөц чанарыг ялган дүйхэд тэдгээр оюутнуудын 54 (14.17%)-д нь хийн, 76 (19.95%)-д нь шарын, 51 (13.39)-д нь бадганы өвөрмөц чанар голлосон бол хий+шар хавсарсан 53 (13.91%), бадгана+шар хавсарсан 52 (13.65%), бадгана+хий хавсарсан 28 (7.35%), хурмалын өвөрмөц чанартай 67 (17.59%) оюутан байлаа. Биеийн өвөрмөц чанар нь тухайн бодгалийн хүйснээс хамаарч ялгаатай тархалттай байв (P<0.05). Биеийн жингийн индексээс хамааруулан биеийн өвөрмөц чанарыг судлахад. биеийн жингийн индекс багатай оюутны дунд бадгана шар хавсарсан өвөрмөц чанартай 2.5%, эсрэгээрээ биеийн жингийн индекс ихтэй оюутны бүлэгт бадгана болон бадгана шарын өвөрмөц чанар 23.8%, 28.6% тус тус тодорхойлогдсон. Харин биеийн жингийн индекс хэвийн бүлэгт шар, хий шарын өвөрмөц чанар давамгайлж, бадгана, хий+бадгана хосолсон өвөрмөц чанартай нь харьцангуй цөөн тархалттай нь ажиглагдлаа (P<0,05). **Дүгнэлт:** 18-25 насны оюутны дунд шарын өвөрмөц чанар голлож байна. Эрэгтэйчүүдтэй харьцуулахад эмэгтэйчүүдийн дунд шарын өвөрмөц чанарын тархалт өндөр (P<0.05). Биеийн өвөрмөц чанар нь биеийн жингийн индексийн ялгаатай бүлгүүдэд статистик ач холбогдол бүхий ялгаатай тархасан (P<0.01) байв.

ӨГҮҮЛЭЛ

Үндэслэл: Монгол анагаах ухааны онолоор “Биеийн өвөрмөц чанар” (БӨЧ) нь эцэг эхийн дусал нийлэн үр хөврөл тогтож, бойжих явцад бүрэлдэх ба амьдралын туршид тухайн бодгалийн онцлогыг тодотгох төрөлх мөн чанар юм. БӨЧ нь тухайн бодгальд 3 махбодийн аль нь давамгайлж байгаагаас хамаарч тогтох ба гадаад дотоод хүчин зүйлийн нөлөөгөөр хувиралд ордог гэж үздэг.[1,2] Монгол анагаах ухаан (МАУ)-д БӨЧ-г хий шар бадганы онолоор суурь, болгож хий шар бадгана 3 дан дангаараа голлох, хоёр хоёроор хавсарч сацуу болж голлох, гурвуулангаар сацуу хурах гэж долоон зүйлд хураангуйлдаг. Хүмүүний бие бялдар, өнгө зүс, хөдөлгөөн, сэтгэхүй, урвалжит чанар, хөдөлгөөн, хандлага, зан авир, авъяас чадвар зэрэг нь тухайн бодгалийн хувьд дахин давтагдашгүй бөгөөд тус тусын онцлог шинжээ хадгалан, хүний биеийн өвөрмөц чанар нь харилцан адилгүй байдаг. Үүний шалтгаан нь голдуу эх эцгийн өвөрмөц чанарын удамшил болон эхийн хэвлийд үр хөврөл бүрэлдэж, хөгжин бойжих явцад эхийн шүтсэн идээ ундаа, явдал мөртэй нягт холбоотой гэж үздэг.[1]

БӨЧ нь хүний биеийн эрүүл чийрэг байх, өвчин эмгэгт өртөх, эс өртөхөд нөлөөлдөг.[2] Тухайлбал МАУ-ны биеийн өвөрмөц чанарыг ялган тогтсон суурин дээр, адил бус өвөрмөц чанартны нэрвэгдэх өвчин, өвчний явц, эрсдэл харилцан адилгүй. Энэ

удаагийн судалгаанд МАУ-ны биеийн өвөрмөц чанарын тархалтыг харьцангуй эрүүл 381 оюутны дунд тодорхойлж, өвөрмөц чанар болон чанарын ялгал, биеийн жингийн индекс хоорондох харьцааг судаллаа.

Зорилго: Монгол анагаах ухааны биеийн өвөрмөц чанарын тархалтыг оюутны биеийн жингээс хамааруулан судлах.

Судалгааны хэрэглэгдэхүүн ба арга зүй:

1. Судалгаанд Өвөр Монголын Анагаах Ухааны Их Сургууль (ӨМАУИС)-ийн 2-оос 4 дүгээр дамжааны оюутныг хамруулав
2. Биеийн өвөрмөц чанарыг тогтоох
   1.2.1 БӨЧ-ийг тогтоох арга: Б.Жигмэд "Монгол Анагаах Ухааны Үндсэн Онол"[3] дах биеийн өвөрмөц чанарын ерөнхий илрэлийг үндэслэн, биеийн өвөрмөц чанарыг ялган тогтоов.
   1.2.2 БӨЧ-ыг тогтоох баримжаа: Судалгааны хуудсаа хураажавсаныдараа Өлзийбаатарын хийсэн аргаар[4] судалгаанд оролцогч бүрт үнэлгээ өгч, өвөрмөц чанарыг тогтоов. Үүнд: 1) Хий, шар, бадганы аль нэгийг голлосон үнэлгээний хувь нөгөө хоёроос 50%-иас дээш бол тухайн өвөрмөц чанартайд харъяалагдана. 2) хий, шар, бадганы аль алины хувь нь ойролцоо байж, зөрүү нь 50%-иас бага байх мөртлөө, хоюулангийнх эзлэх хувь нь үлдсэн нэгээсээ өндөр бол тухайн 2 өвөрмөц чанар хавсарсанд тооцно.
3. Хий, шар, бадганы эзлэх хувь тэнцүү байвал хурмалын өвөрмөц чанарт багтана.
   1.3 Судалгаанд хамруулах болон хасах шалгуур
   1.3.1 Судалгаанд хамруулах шалгуур
      1. 18-25 насны оюутан, сайн дурын үндсэн дээр судалгаанд оролцоно.
      2. Оролцогчидоос асуумж авч, ерөнхий үзлэг хийх (биеийн халуун, цусны даралт, амьсгал, зүрхний цохилтыг шалгах)
      3. Үзлэг болон шинжилгээгээр өөрчлөлт илрээгүй байх.
      4. Асуумжид архаг ужиг өвчингүй байх
      5. Сүүлийн нэг сарын хугацаанд ямар нэг эм, тариа хэрэглээгүй байх
      6. Сайн дураар судалгаанд хамрагдахыг зөвшөөрсөн
   1.3.2 Судалгаанаас хасах шалгуур:
      1. Удамшилын өвчин, эсвэл халдварт өвчний өгүүлэмжтэй
      2. Дээрхи судалгааны шалгуур үзүүлэлтийг хангаагүй.
      3. Судалгааны асуумжийг дутуу бөглөсөн
   1.4 Статистик боловсруулалтыг Материалын тоо баримт ба бүртгэл зүйн арга (X2-test) тестээр задлалт хийсэн.

Үр дүн:

Оюутны дунд биеийн өвөрмөц чанарын тархалтын байдал: Судалгаанд 18-25 насны 391 оюутныг хамруулсан. Асуумж авч өрөнхий үзлэг хийж үзэхэд, судалгаанд орох шалгуур үзүүлэлтийг хангасан 381 (97.7%) оюутан байв. Үүнээс эрэгтэй 122 (32.02%), эмэгтэй 259 (67.97%). Эдгээр оюутны дунд БӨЧ-ийн тархалтыг тогтооход 54 (14.17%)-т нь хийн, 76 (19.95%)-д нь шарын, 51 (13.39%)-д нь бадганы өвөрмөц чанар голлож, хий шар хавсарсан 53 (13.91%), бадгана шар хавсарсан 52 (13.65%), бадгана хий хавсарсан 28 (7.35%), хурмалын өвөрмөц чанартай 67 (17.59%) оюутан байв (Хүснэгт 1). Дээрх үр дүн нь 8-25 насны оюутан залуучуудын дунд бадгана+хий хавсарсан төлөвөөс бусад өвөрмөц чанар харьцангуй жигд тархалттай болохыг харуулж байна

.

Хүснэгт 1. Биеийн өвөрмөц чанарын тархалт

Биеийн өвөрчлөл	Тохиолдлын тоо (N)	Тархалт (%)
Хий	54	14.17
Шар	76	19.95
Бадгана	51	13.39
Хий+шар	53	13.91
Бадгана+шар	52	13.65
Бадгана+хий	28	7.35
Хурмал	67	17.59
Нийт	381	100.0

Биеийн өвөрмөц чанарын тархалтыг хүйснээс хамааруулан судалсан дүн: Биеийн өвөрмөц чанарын тархалтыг бодгалийн хүйснээс хамааруулан судлахад эрэгтэй оюутны 23 (18.35%)-д хийн, 17 (13.93%)-д шарын, 12 (9.84%)-д бадганы өвөрмөц чанар голлож, 21 (17.21%)-д хий+шар, 20 (16.39%)-д бадгана+шар 5(4.10%) –д бадгана+хий хавсарч, үлдсэн 24 (19.35%)-т нь хурмалын өвөрмөц чанар давамгайлжээ. Харин эмэгтэй оюутны 31 (11.97%) нь хийн, 59 (22.78%) нь шарын, 39(15.06%)-нь бадганы өвөрмөц чанартай байсан бол, хий+шар хавсарсан 32 (12.36%), бадгана+шар хавсарсан 32 (12.36%), бадгана +хий хавсарсан 23 (8.88%), хурмалын өвөрмөц чанартай 43 (16.60%) охид бүсгүйчүүд тус тус бүртгэгджээ (Хүснэгт 2). Дээрх үр дүнгээс БӨЧ хүйснээс хамаарч оюутнуудын дунд ялгаатай тархалттай болох нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл шарын өвөрмөц чанар нь эр эм хүйсэд илэрхий ялгаатай буюу эрэгтэйтэй харьцуулахад эмэгтэй оюутны дунд шарын өвөрмөц чанар нь илүү их тархалттай байгаа (P<0,05) нь ажиглагдав.

Хүснэгт 2. Биеийн өвөрмөц чанарыг хүйснээс хамааруулсан дүн

Биеийн өвөрмөц чанар	Эрэгтэй n (%)	Эмэгтэй n (%)	P утга
Хий	23(18.85)	31(11.97)	
Шар	17(13.93)*	59(22.78)	p<0.05
Бадгана	12(9.84)	39(15.06)	
Хий+шар	21(17.21)	32(12.36)	
Бадгана+шар	20(16.39)	32(12.36)	
Бадгана+хий	5(4.10)	23(8.88)	
Хурмал	24(19.7)	43(16.60)	
Нийт	122(100)	259(100)	

Тайлбар: эрэгтэй эмэгтэй бүлэгт БӨЧ илт ялгаатай, буюу *P<0,05 болохыг илэрхиилнэ.

БӨЧ-ыг биеийн жингийн индексээс хамааруулан судалсан дүн: Биеийн жингийн индекс (БЖИ)-ээр нь оюутнуудыг БЖИ багатай (<18.5), хэвийн (18.5-24.0), их (24.0<) гэсэн 3 бүлэг болгож БӨЧ-ыг судлав. Судалгаанд оролцогсдын 40 (10.5%) нь БЖИ багатай ба үүнээс эрэгтэй 16 (40%), эмэгтэй 34(60%) оюутан байна. Тэдгээрээс 9 (22.5%)-д нь хийн, 6 (15%)-д нь шарын, 7 (17.5%)-д нь бадганы өвөрмөц чанар голлосон ба, хий+шар хавсарсан 5 (12.5%), бадгана+шар хавсарсан 1 (2.5%), бадгана+хий хавсарсан 5 (12.5%), хурмалын өвөрмөц чанартай 7 (17.5%), оюутан байв (Хүснэгт 3,4). Дээрх үзүүлэлт нь биеийн жингийн индекс багатай оюутны дунд бадгана шар хавсарсан өвөрмөц чанар статистик ач холбогдол бүхий цөөхөн тохиолдож байгааг харуулж байна (P<0,05).

БЖИ хэвийн 278 (72.97%) оюутан судалгаанд орсоноос эр 88 (31.65%), эм 190 (38.35%) байна. Үүнээс хийн өвөрмөц чанар 40 (14.4%), шарын өвөрмөц чанар 60 (21,6%), бадганы өвөрмөц чанар 29 (19.4%), хий+шар хавсарсан 46 (16.5%), бадгана+шар хавсарсан 33 (19.9%), бадгана+хий хавсарсан 21 (7.6%), хурмалын ӨЧ-тай 49(17.6%) оюутан байна. БЖИ хэвийн бүлэгт шар, хий шарын өвөрмөц чанар давамгайлж (P<0,05), бадгана, хий+бадганы өвөрмөц чанартай нь харьцангуй цөөн тархалттай байгаа нь ажиглагдлаа (P<0,05).

БЖИ ихтэй 63 (16.53%) оюутны 28 (44.44%) нь эрэгтэй, 35 (55.56%) нь эмэгтэй байгаагаас 5 (5.9%)-д нь, хийн, 10 (15.8%)-д нь шарын, 15 (23,8%)-днь бадганы өвөрмөц чанар голлож, хий+шар хавсарсан 2 (3.2%), бадгана+шар хавсарсан 18 (28,6%), бадгана+хий хавсарсан 2 (3.2%), хурмалын өвөрмөц чанартай 11 (17.5%) оюутан байна (Хүснэгт 3,4). БЖИ ихтэй оюутнуудын дунд бадгана (P<0,05), бадгана +шарын(P<0,01) өвөрмөц чанар давамгайлж байна.

Оюутнуудын БӨЧ-аас хамаарч БЖИ ялгаатай тодорхойлогдож (P<0.01) байна. Үүнд БЖИ багатай бүлэгт бадгана шарын өвөрмөц чанар илт ялгаатай (P<0.05), бусад нь жигд тархалттай байна. Харин тооны харьцаанаас харвал хийн өвөрмөц чанар нь хамгийн их (22.5%) тархалттай байна. БЖИ хэвийн (18.5≤БЖИ<2.0) бүлэгт бадгана болон хий+ шарын хавсарсан өвөрмөц чанар нь илт цөөн ч тоо (P<0,05)-н харьцаанаас харвал шар болон хурмалын ӨЧ хамгийн их буюу тус бүр 21.6%, 17.6% байна. Илүүдэл жин (БЖИ≥24.0)-тэй оюутны бүлэгт бадганы (P<0,05) болон бадгана+шарын өвөрмөц чанар илт (P<0,01) зөрүүтэй, тус тус 23.8%, 28.6% тодорхойлогдсон нь хамгийн их тархалттай болно. (Хүснэгт 3,4).

Хүснэгт 3. Биеийн өвөрмөц чанар ба БЖИ-ийн тархалтын байдал

Биеийн	Биеийн жингийн индекс n(%)		
Өвөрмөц чанар	18.5>	18.5-24	24.0<
Хий	9(22.5)	40(14.4)	5(7.9)
Шар	6(15.0)	60(21.6)	10(15.9)
Бадгана	7(17.5)	29(10.4)*	15(23.8)*
Хий+шар	5(12.5)	46(16.5)*	2(3.2)
Бадгана+шар	1(2.5)*	33(19.9)	18(28.6)**
Бадгана+хий	5(12.5)	21(7.6)*	2(3.2)
Хурмал	7(17.5)	49(17.6)	11(17.5)
Нийт	40(100)	278(100)	63(100)

Тайлбар: БЖИ болон БӨЧ-ийн хоорондох илт зөрөөтэй. болохыг *P<0.05, **P<0.01–ээр илэрхийлэв.

Хий, шар, бадгана, хурмал зэрэг биеийн өвөрмөц чанарыг БЖИ–ээс хамааруулан үзвэл: Хийн өвөрмөц чанар БЖИ-ийн ялгаатай (бага, хэвийн, их) бүлгүүдэд 22.5%, 14.4%, 7.9% тохиолдсон нь хийн өвөрмөц чанар туранхай (18.5>БЖИ) буюу БЖИ багатай бүлэтт илүүтэй тархсаныг харуулж байна.

БЖИ-ийн ялгаатай (бага, хэвийн, их) бүлгүүдэд шарын өвөрмөц чанар нь 15.0%, 21.6%, 15.9% харьцаагаар тодорхойлогджээ. Өөрөөр хэлбэл шарын өвөрмөц чанар нь БЖИ хэвийн бүлэгт (18.5≤БЖИ<2.,0) өргөн тархсан байна.

Хүснэгт 4. Оюутны хүйс ба биеийн жингийн индекс

Хүйс	БЖИ <18.5	18.5≤ БЖИ <24.0	БЖИ ≥24.0	нийт
Эрэгтэй n (%)	6 (4.9)*	88 (72.1)	28 (23)*	122 (100)
Эмэгтэй n (%)	34 (13.1)	190 (73.4)	35 (13.5)	259 (100)

Тайлбар: * (P<0,01)эрэгтэй эмэгтэй хүйст ач холбогдол бүхий ялгаатай байгааг илэрхийлнэ

БЖИ-ийн ялгаатай (бага, хэвийн, их) бүлгүүдэд бадганы өвөрмөц чанар 17.5%, 10.4%, 23.8% тохиолджээ. Иймээс бадганы өвөрмөц чанар БЖИ ихтэй (БЖИ≥24.0) оюутны дунд өргөн тархалттай байна.

Хурмалын өвөрмөц чанар БЖИ-ийн ялгаатай бүлгүүдэд ижил 17.5% байгаа нь хурмалын өвөрмөц чанар БЖИ-ийн ихсэлт бууралтаас үл хамаарч жигд тархалттай болохыг харуулж байна. Оюутны хүйснээс хамаарч БЖИ харилцан адилгүй тодорхойлогдлоо. Эрэгтэй оюутнуудын 72.1% (88), эмэгтэйчүүдийн 73.4% (190)–д БЖИ хэвийн (18.5≤БЖИ<24.0) хэмжээнд байв (Хүснэгт 4). БЖИ багатай бүлэгт эрэгтэй 6 (4.9%), эмэгтэй 34 (13.1%), илүүдэл жинтэй бүлэгт эрэгтэй 28 (23.0%), эмэгтэй 35 (13.5%). Дээрх үзүүлэлт нь эрэгтэй оюутан харьцангуй илүүдэл жинтэй байж, эмэгтэй оюутан БЖИ багатай болохыг харуулж байна. (P<0.01). БЖИ хэвийнээс их эсвэл бага байх нь эмэгтэйчүүдтэй харьцуулахад эрэгтэй оюутны дунд илүүтэй ажиглагдлаа (P<0.01).

Хэлцэмж: Энэ удаагийн судалгаанд 18-25 насны оюутан залуусыг хамруулж БӨЧ-ыг хүйс болон биеийн жингийн индекстэй харьцуулан судлав. МАУ-нд биеийн өвөрмөц чанарыг хүний насны хувиралтыг үндэслэн судлахад хүүхдэд бадганы, залуу идэр насныхны дунд шарын, хөгшдөд хийн өвөрмөц чанар голлодог гэж үздэг.[5] Энэхүү судалгааны дүнгээс үзэхэд 18-25 насны оюутануудын дунд шарын өвөрмөц чанартай залуучууд голлож байгаа нь дээрх судалгааны дүнтэй үндсэндээ дүйж байна. Оюутан залуучуудын дунд голлож байгаа шарын өвөрмөц чанарын дараа хурмал ба хавсарсан өвөрмөц чанар удааллаа. Энэ нь МАУ-дах “хий, шар, бадгана, хавсарсан 3, хурмал зэрэг 7 зүйлийн өвөрмөц чанарыг амьдралын мөн

чанартай харьцуулбал, дээрээс дэс дараалан сүүлийнх нь өмнөхөөсөө давуу байдаг”[6] гэсэн үр дүнтэй нийцэж байна. Манай судалгааны дүнгээс харахад БӨЧ-ын тархалт нь хүйснээс хамаарч эрэгтэй, эмэгтэй оюутны дунд илэрхий ялгаатай тархсан (P<0,05) ба шарын ӨЧ эмэгтэй оюутны дунд харьцангуй их байна. Энэхүү үзүүлэлт нь Өлзийбаатарын “Их сургуулийн оюутны БӨЧ-ыг судалсан судалгаа’-ны[7] дүнгээс ялгаатай байгаа нь манай судалгаанд эмэгтэй оюутнууд илүү хамрагдсантай холбоотой байж болох юм.

БӨЧ-ын адил бусаас болж, бие бялдарын хөгжлийн илрэл харилцан адилгүй. Үүнд: хийн ӨЧ бие бялдар багатай, бөгтгөр, хатингар харагддаг бол шарын өвөрмөц чанартай хүмүүсийн бие бялдар нь дунд зэрэг, харин бадганы өвөрмөц чанартай хүмүүс биерхэг бөгөөд мах мяраатай байдаг. Эдүгээ хүний биеийн тарган туранхай болон эрүүл эсэхийг биеийн жингийн индекс (БЖИ)-ээр илэрхийлж байна.[8] Иймээс энэхүү судалгаанд оюутны БЖИ-ийг биеийн өвөрмөц чанараас хамааруулан судлав. Судалгааны дүнгээс үзэхэд оюутнуудын олонхид БЖИ хэвийн ба тэдний дотор шарын ӨЧ хамгийн өргөн тархсан байна. Харин БЖИI багатай оюутнуудын дунд хийн ӨЧ их, жингийн илүүдэлтэй оюутнуудад бадгана болон бадгана+ шарын ӨЧ их тархалттай байгаа нь У. Сэцэнбилэг нарын “Эрүүл хүний биеийн өвөрмөц чанар болон БЖИI хоорондох холбогдох чанарыг судалсан дүнтэй адил байна.[9]

Хий, шар, бадгана, хурмал зэрэг ӨЧ нь БЖИ-ийн ялгаатай бүлгүүдэд жигд бус тархсан байна. Үүнд БЖИ багатай бүлэгт хийн ӨЧ хамгийн их тархалттай байгаа бол шарын ӨЧ нь БЖИ хэвийн бүлэгт, бадганын өвөрчлөл БЖИ их оюутны дунд илүүтэйгээр тархжээ. Харин хурмалын ӨЧ нь БЖИ-ийн 3 бүлэтт жигд тархсан байна.

Судалгаанд оролцогсодын биеийн өвөрмөц чанарын ялгаанаас болж БЖИ нь илт ялгаатай байна. (P<0,01). Эрэгтэй оюутан харьцангуй жингийн илүүдэлтэй, эмэгтэй оюутны БЖИ харьцангуй бага байна. Энэхүү дүн нь бусад судлаачдын биеийн өвөрмөц чанарын ялгал болон БЖИ-ийн тухай судалж байсан дүнтэй ойролцоо байлаа. Энэхүү үр дүн нь эмэгтэй оюутны энгийн үедээ өөрийн бие цогцост анхаарч, илүүдэл жингээ хасах, эрүүл мэндийн боловсролыг илүү анхаарах, зөв зохистой хооллох зэрэг амьдралын хэвшилтэй холбоотой байж мэднэ. Харин эрэгтэй оюутны хувьд дээрх хүчин зүйлийг сайтар анхаардаггүйгээс илүүдэл жинтэй болох эрсдэлийг дагуулдаг байж магадгүй. Судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэвээс 18-25 насны хоорондох оюутан залуусын дунд шарын өвөрмөц чанар голлож, хурмалын ӨЧ удаалж байгаа нь МАУ-ны идэр насны хүмүүс шарын ӨЧ-аар голлох онолтой нийцнэ.

Хүйснээс хамаарч оюутны дунд биеийн өвөрмөц чанарын хэлбэрүүд ач холбогдол бүхий ялгаатай тархсан байгаа нь эрэгтэй эмэгтэй хүний өдөр тутмын амьдралын дадал зуршил, бодол санаа ижил бустай холбоотой. Хий, шар, бадганы өвөрмөц чанартны БЖИ харилцан ялгаатай. Энэ нь МАУ-ны онолын хийн ӨЧ-ны бие бялдар бага, бөгцгөр, хатингар Шарын ӨЧ-ны бие бялдар нь дунд зэрэг, бадганы ӨЧ-ны том бөгөөд мах мяраатай ихтэй байдагтай нийцэж байна. Энэ удаа МАУ-ны БӨЧ-ын тархалтын байдлыг зөвхөн 18-25 насны хоорондох харьцангуй эрүүл оюутныг хамруулан эрүүл зүй, идэр залуучууд, чанарын ялгал, биеийн жингийн индекстэй хамааруулан суудалсан болно. Судалгаанд цөөн оюутныг оролцсон ба сургуулийн онцлогоос хамаарч эмэгтэй оюутууд давамгай хамрагдсан нь судалгааны ажлын хязгаардагдал тал болох ч энэхүү ажлын ач холбогдлыг бууруулахгүй гэж үзэж байна. Бид дараа дараагийн судалгаанд судлагдахууны тоог нэмэгдүүлж, нас хүйсний зөрүү, үндэсний соёл, зан чанар, орон нутагийн онцлог, амьдралын зуршил зэрэг олон талаас МАУ-ны БӨЧ болон эдгээрийн хоорондох харьцааг дэлгэрүүлэн судлууштай.

ӨГҮҮЛЭЛ

Ном зүй:

1. *Бай Чин Юань, Дундад улсын анагаах ухааны нэвтэрхий толь: Монгол анагаах ухаан (дэд) [М],.Өвөр Монголын ШУ-ны техник мэргэжлийн хэвлэлийн хороо, 1987:44-45.*
2. 布仁达来，研究建立蒙医体质学理论体系的构思[J]. 中国民族医药杂志，2007（01）：49 ~ 50.
3. *Б.Жигмэд. Монгол анагаах ухааны үндсэн онол(гуравдугаар хэвлэл) [М]. Хөххот:Өвөр монголын их сургуулийн хэвлэлийн хороо,2014:111-113.*
4. 乌力吉巴特尔，瑟•彬巴苏荣，色•色日格道尔吉，中国大学生蒙医个性气质类型的调查与分析[J]. 亚太传统医药，2011，7（1）：129-130.
5. *Бай Чин Юань, Дундад улсын анагаах ухааны нэвтэрхий толь: Монгол анагаах ухаан (дэд) [М],.Өвөр Монголын ШУ-ны техник мэргэжлийн хэвлэлийн хороо, 1987:44-45.*
6. *Бай Чин Юань, Дундад улсын анагаах ухааны нэвтэрхий толь: Монгол анагаах ухаан (дэд) [М],.Өвөр Монголын ШУ-ны техник мэргэжлийн хэвлэлийн хороо, 1987:44-45.*
7. 乌力吉巴特尔，瑟•彬巴苏荣，色•色日格道尔吉，中国大学生蒙医个性气质类型的调查与分析[J]. 亚太传统医药，2011，7（1）：129-130.
8. [8] 王乐融，体重指数、腰围与生命质量的关系：运动的调节效应[D]. 北京中医药大学，2019.
9. [9] 吴斯琴毕力格，高敬贤，白长喜. 蒙医不同体质对血常规、尿常规及身体质量指数的影响[J]. 中华中医药杂志，2018，33（7）：3086-3088.

Distribution of constitutional types among students in the University of Mongolian traditional medicine

Zangin[1], Zunaa[2], Wan Yue Hun[3], Ts.Odgerel[4,5]

[1]PhD student of the University of Mongolian Traditional Medicine (UMTM),
[2]Student of the UMTM
[3]Department of Internal Medicine, UMTM, Inner Mongolia,
[4]Department of Hematology, School of Medicine, MNUMS
5Mongol-JapanTeaching Hospital of MNUMS

Introduction: According to the Mongolian Traditional Medicine theory, “Constitutional types of body" is formed when the male and female gamete fuse, developed, matured, during embryogenesis, and define individual's personality throughout the life.
Purpose: This study was aimed to clarify posible relatonship beween body mass index and constitutional types among students in the University of Mongolian Tradional Medicine of Inner Mongolia, Republic of China.
Materials and methods: Medical studnents were enrolled in this crosssectional study. Body constitutional types of the participants were identified by physical examination on the basis of observational method of Mongolian Traditional Medicine.
Results: Total of 381 students were enrolled in this study, in which 122 (32.02%) were male and 259 (67.98%) were female. 54 (14.17%) of those students had single Khii, 76 (19.95%) had single Shar, 51 (13.39%) had single Badgana type, 53 (13.91%) had Khii+Shar, 52 (13.65%) had Badgana+Shar, 28 (7.35%) had Badgana+Khii combined dual types, and 67 (17.59%) had triple types. Depending on gender constitutional types were differentially distributed (P<0.05). Comparision of constitutional types to BMI, badgana (or phlegm or bile) and badgana+shar was very low among students with low BMI, totaling 2.5%. However, for students with high BMI, badgana and badgana combined with shar were widelly distributed 23.8%, 28.6% respectively. In a group of students with normal BMI, single shar and shar combined with Khii (rlungor wind or vital energy) were dominated (P<0.05), and types of badgana and Khii+badgana were very low.
Conclusion: The most prevalent constitutinal types among Medical School students aged 18-28 years was Shar or Tripa (Fire). Compared to males, females had more case of single Shar (P<0.05). There were statistical significance in the distribution of constitutional types in group of students with different body mass index (P<0.01).

Keywords: Mongolian traditional medicine, body constitutional type, body mass index